

Буддын ёс зүйн нэр томъёоны судалгаанд
мета ёс зүйн арга зүйг хэрэглэх нь

Мөнхцэрэнгийн ЗОЛЗАЯА*
Монгол Улс, Улаанбаатар,
Соёл, урлагийн их сургуулийн харьяа
Соёл, урлаг судлалын хүрээлэн

Received: April 15, 2025 | Accepted: September 26, 2025 | Published: October 15, 2025

Хураангуй: XX зуунд аналитик философичид ёс суртахууны харилцаа, үнэлэмжийг илэрхийлсэн категори, ухагдахууны онтологи, эпистемологи, логикийн асуудлыг судлах болсон юм. Энэ хүрээнд шашны ёс зүйн нэр томъёоны асуудал ч хамаарна. Сүүлийн үед өрнийн буддын судлаачид мета ёс зүйн үүднээс буддын үзэл санааг судлах болсон хэдий ч буддизм дэлгэрсэн орнуудад буддын ёс зүйн нэр томъёоны хэрэглээ ямар түвшинд буйг харьцуулсан судалгаа хомс байна. Мета ёс зүйн арга зүй нь буддын мэдлэг ухааныг шинжлэх ухааны нэр томъёо судлалын үүднээс авч үзэхэд чухал юм. Иймээс мета ёс зүйн арга зүйг буддын ёс зүйн судалгаанд харгалзах онол, арга зүйн зарим асуудал хийгээд Шантидэва гэгээний айлдсан «Бодьсадвын явдалд орохуй» шастирын тайлбар зохиолоос зарим нэр томъёоны оноолт, орчуулгыг жишээгээр харуулахыг зорьсон болно.

Түлхүүр үг: ёс суртахууны хэл, мета онол, аналитик философи, мета илэрхийлэл

* © М.Золзаяа, 2025

Email: zolzaya.m@mnuac.edu.mn,  <https://orcid.org/0000-0001-6083-1445>



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license.

Applying Meta-Ethical Methodology to the Study of Buddhist Ethical Terminology

ZOLZAYA Munkhtseren

The Research Institute of Culture and Arts,
Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia

Abstract: *In the 20th century, analytical philosophers began to study the ontology, epistemology, and logic of words and concepts expressing moral relation and values. In this context, it is necessary to carefully study the terms in Buddhist ethics. Therefore, in this paper, the importance of metaethical methodology is considered the translation and usage of Buddhist ethical terms. Recently, Buddhist scholars studying Buddhist views from the perspective of metaethics, but it expressed fewer that the problems of practical application of the terms in the Mongolian buddhism. So, the author try to consider the applying method of methodology of meta-ethics to Buddhist ethics, and examples of the some Buddhist terms definition and translation from Mongolian commentary of "Bodhicaryāvatāra" written by Shantideva.*

Keywords: *moral language, meta theory, analytic philosophy, meta-expression*

1. Удиртгал

Судалгааны бүтээлүүдэд буддист ёс зүй, буддизмын ёс зүй, буддын ёс зүй гэсэн ухагдахуунууд адил утгаар хэрэглэгдэх нь түгээмэл боловч эдгээр нь өөр хоорондоо ялгаатай юм. Буддист ёс зүй нь Буддагийн сургаалыг даган баримтлагчдын үзэл санааны уламжлал дахь ёс зүйн сургаал, түүний арга зүйн баримтлалыг хамтад нь илэрхийлсэн ойлголт юм. Харин “буддизмын ёс зүй” нь Буддагийн сургаалд үндэслэсэн ёс суртахууны хэм хэмжээ, зарчмын цогцыг илэрхийлэх бөгөөд буддын ёс зүйтэй агуулгын хувьд ижил. Буддын ёс зүй нь буддизмын үзэл санааны уламжлалд суурилсан ёс суртахууны хэм хэмжээ, зарчмыг илэрхийлдэг гэж болно. Буддын мета ёс зүйн хүрээнд буддын ёс зүйн категори, нэр томъёог логик-хэл шинжлэлийн үүднээс тодорхойлон тайлбарласан судалгаа хийгддэг юм.

Ёс суртахууны философид норматив ба мета ёс зүй гэсэн хоёр хандлага байдаг. Норматив ёс зүй нь сайн үйл гэж юу вэ, бид сайн, зөвийг хэрхэн үйлдэх вэ гэдгийг хэм хэмжээний тогтолцоогоор авч үздэг салбар. Мета ёс зүй нь ийм асуудлыг илүү дэлгэрүүлж судалдаг. Ёс суртахууны баримтат бодомж танин мэдэхүйн хувьд үнэн эсвэл худал байх боломжтой юу?, сайхан сэтгэлээр хандах нь туршлага, дүрэм журамд нийцсэн ч мэдлэг, эргэцүүлэх сэтгэлгээ дутагдвал яах вэ? Когнитивистууд туршлагаас олж мэдсэн ёс суртахууны тухай ойлголт

нь ямар үйлдэлд тулгуурлаж байгааг голчилдог. Харин неонкогнитивистууд ёс суртахууныг мэдрэмжээрээ дагаж мөрдөх зан үйлийн хэм хэмжээ гэж үздэг.

Тус өгүүлэлд буддын ёс зүйн судалгаанд мета ёс зүйн арга зүйг хэрэглэх тухай авч үзэхийг оролдов. НТӨ V зуунд Сократын сургаалаас эхлэн философид ёс суртахууны хэлний мөн чанарыг авч үзсэн уламжлал нь XX зуунд мета ёс зүйн чиглэл үүсэж хөгжихөд хүргэсэн юм. Мета ёс зүйн үндэс болох Ж.Э.Мурын “Ёс зүйн зарчмууд” (1903) бүтээлд *“Мета ёс зүйн зорилго бол сайн, үүрэг гэж юу болохыг тодорхойлоход биш, харин эдгээрийг онол, логик сэтгэхүйн талаас үндэслэж тайлбарлахад оршдог. Хэлний функц, онтологийг илрүүлэх мета хандлага нь ёс зүйн “сайн” хэмээх үнэлэмжийг илэрхийлсэн категорийг тодорхойлоход гаргасан натуралист алдааг логикийн үүднээс залруулах боломжийг олгоно”* гэсэн байна. 1944 онд Ч.Л.Стивенсон “Ёс зүй ба хэл”, 1952 онд Р.М.Хэра “Ёс суртахууны хэл” хэмээх бүтээлүүдээ туурвижээ. Тэд уламжлалт ёс суртахууны философид “ёс зүйг ёс суртахууны тухай шинжлэх ухаан” (1952: 202) гэж тодорхойлж байсныг залруулж, “ёс зүй бол ёс суртахууны тухай мэдлэг, түүний судлагдахуун нь хэл байх ёстой” гэж үзжээ. Жишээ нь, бусдын нэр төрийг гутаах нь буруу, бусдын нэр төрийг гутаах нь буруу учир би ийм алхам хийхгүй, бусдын нэр төрийг гутаах нь буруу байх магадлалтай гэсэн гурван бодомжийн эхнийх нь шууд илэрхийлэл, бусад нь дагаж үүссэн бодомж хэмээн эдгээрийн хэлний логикийг нь авч үзэж буй юм.

Мета ёс зүй нь ёс суртахууны хэлийг¹ судалдаг салбар. Ж.Э.Мур, Р.М.Хэра, А.Айер, Ч.Л.Стивенсон, Жеофрэй Сэурэ-Мс Корд нарын философич эрдэмтэд ёс суртахууны хэл, үгийн сонголт, натуралист алдаа² логикийн дүрэм зөрчигдсөнөөс үүдэх үр дагавар, хэрхэн зөв гаргалгаа хийх зэрэг асуудлыг судалж, мета ёс зүйг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулсан байдаг. Аналитик философид ерөнхийдөө танин мэдэхүй ба метафизикийн харилцааны асуудал зонхилж (ялангуяа неопозитивист хандлагад) байсан бол, мета ёс зүйд мэдлэг, үнэлэмжийн харьцааны асуудал эн тэргүүнд гарч иржээ. Энэ нь 1) ёс суртахууны үнэлэмж нь дундаж байж болох эсэх, 2) ёс суртахууны үнэлэмжийн утгатай үг хэллэг нь когнитив байр суурьтай эсэх, 3) эдгээрийн үнэн, худлыг шалгаж болох эсэх тухай асуудал юм. Иймд мета ёс зүйн шинжилгээ нь нийгэм-практикийн асуудлаас илүү онолын танин мэдэхүйн үүднээс хандах учир оновчтой дүгнэлтэд хүрэх боломжтой гэж үздэг. Мета ёс зүй судлаачид өөрсдийн судалгааг “ёс суртахууны тухай шинжлэх ухааны философи” буюу онолын ёс зүй гэж нэрлэдэг. Харин уламжлалт ёс суртахууны философийг “норматив ёс зүй” хэмээдэг.

¹ Ethical language буюу ёс зүйн хэл гэсэн томъёолол.

² Тодорхойлж буй болон тодорхойлогдож буй нь ойлголтод илрэх логик зөрчлийг тэмдэглэдэг мета ёс зүйн нэр томъёо.

2. Судалгааны арга зүй

Мета ёс зүй нь логик анализын аргаар ёс суртахууны хэлийг судлан нэр томьёо, ухагдахууны тодорхойлолт боловсруулахад шаардлагатай мэдээллийг бий болгож байна. Мета ёс зүй нь ёс суртахууны онолчдын үзэл баримтлал, үнэлэлт дүгнэлтийг шүүн хэлэлцэх замаар онолын мэтгэлцээн өрнүүлэх үйл явц юм. Үүнийг логик-хэл шинжлэлийн үе шат буюу метагийн мета түвшин хэмээдэг. Иймд буддын эх зохиол болон тайлбар зохиол дахь зарим нэр томьёоны тайлбарын орчуулгыг концептуаль анализын арга зүйд тулгуурлан авч үзэв. Концептуаль анализын арга зүй нь нэр томьёо, ухагдахууны утгыг нарийвчлан тодруулах, ялангуяа сайн, зөв, буян гэх мэт ижил төсөөтэй ойлголтын ялгаа, заагийг гаргахад хэрэглэгддэг. Тус арга зүй нь ёс суртахуун, сэтгэл зүйн төлөв байдлаас хамаарч үнэлэмж өөрчлөгддөг субъектив байр суурийг тодорхойлоход чухал бөгөөд ёс зүйн асуудалд хангалттай үндэслэл дэвшүүлэх нөхцөл болно.

3. Буддын ёс зүйн нэр томьёог мета түвшинд авч үзэх нь

Нэрт буддын судлаач, академич Ф.И.Щербатской “Буддын шашны анхны сургаалаас эхлээд дхарма нь ихэвчлэн ёс суртахууны ягшмал номлол, ёс суртахууны үүрэг гэсэн утгыг хадгалсаар ирсэн. Хинаяана, махаяана чиглэлүүд эхнээсээ дхармыг гүнзгий боловсруулж, оршихуйн элемент гэж үздэг байв” гэж дүгнэжээ (Бонгард-Леви, 1972: 31). “Олон улсын ёс зүйн нэвтэрхий толь”-д буддизмд зовлон, түүний шалтгаан, үрийг ухаарснаар хүн аяндаа гэм хийх хүсэлгүй болно гэж сургадаг. Тиймээс энэ бол олон нийтэд ач тустай сургаал” (Buddhist Ethics, 1995) хэмээн үзсэн байна.

Буддын шашинд хэлээр үйлдэх буян, нүглийн тухай авч үздэг. Чухамдаа бие, хэл, сэтгэлийн гурвал харилцааг суурь болгон, ёс суртахууны хэм хэмжээ, зарчмыг оногдохуун болгож байна. Өөрөөр хэлбэл, хэлээр үйлдэхүй нь сэтгэхүйг суурь болгож, үзэл санааг оногдохуун болгох тийн мэдлийн хуран үйлдэхүй юм. Ийнхүү хэл шинжлэлийн асуудлыг буддизмын үүднээс судлан тайлбарласан бүтээл нь буддын ёс зүйн нэр томьёо судлалд үнэ цэнтэй. Тухайлбал, академич Ш.Лувсанвандан Нагаржунагийн найман үгүйсгэлийг хэрэглэж, фонемын онолын зөрүүтэй асуудлыг шийдвэрлэхийг зорьсон, харин академич Г.Лувсанцэрэн Нагаржунагийн хэлний илэрхийллийн талаарх үзлийг Австрийн Л.Витгенштейний хэл шинжлэлийн философитой харьцуулан тайлбарласан юм.

Буддын гүн ухаан буюу тогтсон тааллын ёсны суурь, мөр, үр хэмээхүйн үүднээс ёс зүйн сургаал, номлол нь зам мөрийн хэсэгт нь хамаардаг гэдэг. Буддын ёс зүйн сургаалыг утга зохиол, хэл шинжлэл, философийн үүднээс судалж ирсэн. Буддын философи судлаач Д.Дагвадорж буддын сургаалыг 1. Хүнийг зовлонгоос гэтэлсэн дээд гэгээрэлд хүргэх мөрийн сургаал, 2. Хүний дотоод сэтгэлээ төгөлдөржүүлэх замаар ариун, нигүүлсэнгүй амьдралд хүргэх мөрийн тухай гэж үзээд, энэ мөрийг “тогтсон таалал” гэнэ. Энэ нь Буддагийн боловсруулсан

нүглийг тэвчин, буян бүтээх замаар ёс суртахууны ариун ёсонд хүрнэ хэмээх үзлийн тогтолцоо (2002: 133) юм гэж тодорхойлжээ.

Академич Г.Лувсанцэрэн Нагаржунагийн “Үндсэн билгийг шүлэглэсэн нь” зохиолын үйл, үрийн тухай 17 дугаар бүлэгт гаргасан зарчмуудад үндэслэн үйл, үйлдэгч, үр гурвыг үнэхээр бүтээгүй, хоосон чанартай гэж гаргаад, үүнийг янагуухын ёсонд хэрхэн ухаарч баримтлахтай холбогдсон асуудлыг авч үзсэн, гэхдээ юуны өмнө дхармын тухай, номын ёсыг онцолж өгүүлсэн байдаг. Үүнд дхармыг дотоод, гадаад бүх юмс гэсэн утгаар ч, сургаал ёс гэсэн санаагаар ч аль аль талаас нь, өөрөөр хэлбэл онтологи, этик аль аль утгыг нь оруулж үзжээ” хэмээн дүгнэсэн (2019: 236) байна. Үүнээс үзвэл, төв үзлийн ёс суртахууны сургаалд үйлийн үр, дхарм, хоосон чанар гэсэн ухагдахуунууд гол аж. Ерөнхийдөө буддын ёс зүйд үйлийн шалтгаан, мөн чанар, үр гурвыг чухалчилна. Эдгээрийн тодорхойлолт, тайлбар нь буддын философийн урсгал чиглэлээс хамаарч янз бүр байдаг.

Өрнөдөд буддын ёс зүйн мөн чанар (Finnigan, 2018: 162), түүнийг өрнийн ёс зүйтэй харьцуулсан (Edelglass William, 2014) болон буддист мета ёс зүйн арга зүйн хандлагын (Finnigan, 2011: 267) талаар судалгаа хийгджээ (Davis, 2013: 24). Өрнийн эрдэмтдийн судалгаанд буддын ёс зүйн уламжлал нь норматив ёс зүй, чухамдаа бол сайн үйлийн ёс зүйн (virtue ethics) нэг хэв маяг гэж үзжээ (Keown, 2001), (Cooper, 2005). 1980-аад оноос Англо-Америкийн ёс суртахууны философид сайн үйлийн ёс зүйг (virtue ethics) дахин дэлгэрүүлэх болж, энэ үеэс зарим эрдэмтэд буддын ёс зүйг Аристотелийн сайн үйлийн ёс зүйтэй адил гэж тайлбарлажээ. Велес де Чеа консеквенциализм, утилитаризмын үүднээс судалж, буддизм нь ёс суртахууны реализм ба утилитаризмын шинжийг өөртөө шингээсэн сайн үйлийн ёс зүй гэсэн бол (2004: 123) буддын ёс зүй нь дадуулж хэвшүүлэх прагматик шинжтэй гэж үзэх хандлага ч байна.

Манай философичид, хэл шинжээчид буддын сэтгэл зүй, ёс зүйн гол ойлголтуудыг тайлбарлажээ. Тухайлбал, “Буддын уламжлалт ухааны үндэс” сурах бичигт гол нэр томъёоны тайлбарыг хавсаргасан (Лувсанцэрэн., Ариунаа, 2007), бурхны шашны сургаалын сэтгэлийн асуудал, түүнд холбогдох үг хэллэгийг (Чоймаа., Янжинсүрэн, 2014: 64) тайлбарласан байдаг. Мөн Агваандандарын сургаалыг мета ёс зүйн үүднээс авч үзэх арга зүйн тухай (Zolzaya, 2019: 342) судалгааг дурдаж болно.

1990-ээд оны сүүлээс хэрэглээний ёс зүй буюу “applied ethics”-т өргөн хэлэлцдэг амьтны жам ёсны эрх, байгаль орчин, дайн, хүчирхийллийн асуудлыг буддын ёс зүйн сургаал номлолтой холбож үзсэн судалгааг хийжээ. Тухайлбал, Оксфордын Их сургуулийн буддын ёс зүйн гарын авлагад (Daniel., Shields, 2018) нийгэм, эдийн засаг, амьтны жам ёсны эрх, эвтанази, экологийн асуудлыг буддизмын үүднээс авч үзсэн байна. Эндээс буддын судлаачид хавсарга ёс зүй рүү орохын тулд социологи, сэтгэл зүй, экологи зэрэг бусад мэргэжлийн үг хэллэг, нэр томъёог анхааралтай судлах шаардлагатай нь харагдаж буй юм. Өрнөдөд хийгдсэн буддист мета ёс зүйн судалгаа нь 1/ буддизмын мэдлэг,

үнэлэмжийн харьцааг тодорхой болгох, 2/ анхдагч эх сурвалжийг англи хэлээр орчуулах, нэр томьёоны утгыг эдүгээчлэн тайлбарлах, 3/ буддын эпистемологийн онол, логик-хэл шинжлэлийг нь судлахад чиглэсэн байна.

3.1. Буддын ёс зүйн нэр томьёоны тухай

Манай судлаачдын хэвлүүлсэн ёс зүйн сурах бичгүүдэд сайн ба муу, шударга ёс, үүрэг, нинжин сэтгэл, нэр төр, аз жаргал зэргийг “ёс зүйн категори”, “ёс зүйн үндсэн ойлголтууд”, “ёс суртахууны ойлголтууд” гэж нэрлэж ирсэн. Ёс зүйн категори гэдэг нь ёс суртахууны харилцаа, ухамсар, үнэлэмжийг тусган илэрхийлдэг бөгөөд ёс зүйд түгээмэл хэрэглэдэг үндсэн ойлголт юм.

Ёс зүйн нэр томьёоны тогтолцоог үзэл сургаал үүссэн газартай нь холбон дорнын, өрнийн, Энэтхэгийн, Хятадын, Японы ёс зүй, буддын ёс зүй, ислам шашны ёс зүй зэргээр ангилдаг. Өрнөдөд буддын ёс зүйг шашны ёс зүй, дорнын буюу Энэтхэгийн ёс зүйн гол чиглэл гэж үзэх бөгөөд нэр томьёог нь санскритаар оноодог. Иймд ёс зүйн нэвтэрхий толиудад дхарма, карма, мокша, абхьяада, адхарма, артха, ахимса, духкха, майтри, нирваан, барамид, сансар, шила, сатья (РАН, 2001) гэх мэт санскрит үгсээр толгойлж тайлбарласан байдаг. Шашны ёс зүйн хүрээнд буддын шашныхаас буян, нүгэл, ахимса, дөрвөн үнэн, карма, нирваан, шила, бодисадва зэрэг нь түгээмэл хэрэглэгджээ (John K Roth, 1995).

Судлаачид буддын ёс зүйн гол нэр томьёонд бодь сэтгэл, арван цагаан буян, арван хар нүгэл, дхарма, зовлон, нигүүлсэл, нирваан, өглөг, дөрвөн үнэн, үйлийн үр, зургаан дадал, найман зөв зам, нисваанисын таван хор зэргийг хамруулсаар ирсэн. Буддын танин мэдэхүйн болон онтологийн үзэл нь өрнөдийнхтэй яв цав тохирохгүй ч ойролцоо утгатай нэр томьёонууд байдаг. Тухайлбал, Оросын болон европын судлаачид буддизмд ethics-ёс зүйтэй ойролцоо утга нь **шила** (санскрит: śīla-зан авир, ёс суртахуун, сайн үйл) буюу зан суртахуун, зан авир, ёс суртахууныг тэмдэглэдэг нэр томьёо гэсэн байна. “Төвөд-монгол хэлний толь бичиг”-т རྒྱལ་ཁབ་-ёс, учир, зан, авир, төр; རྒྱལ་ཁབ་-сахил, шагшаабад (Баясгалан, 1995: 173) гэж буулгажээ. Нийтийн ёсон дахь “трисикша” буюу “гурван суртгаал” (санскрит: trīśikṣā, англи: threefold training, төвөд: lhag-pa'i bslab-pa gsum) буюу (1) śīla (ёс суртахуун), (2) samadhi (бясалгал), (3) prajna (билиг) болно. Мөн судлаач Кеовн cetanā-volition རྒྱལ་ཁབ་-буюу (Keown, 2001) зоригдлыг ёс суртахууны сонголттой холбож үзсэн. “Cetanā” нь сайн үйл бүтээх сэтгэл үүсгэх, үйлдэхийг хамтад нь илэрхийлдэг ба ёс суртахуунаар тодорхойлогддог тул өрнийн философийн практик оюун ухаантай (*Өөрийн болон бусдын амьдралд сайн, зөв, захистойг ялган, түүнд нийцсэн үйлдэл хийх чадвар*) дүйнэ гэсэн саналыг дэвшүүлсэн байна.

Буддын ёс зүйн гол ойлголт болох буяныг ёс суртахуунлаг сайн үйл гэж үздэг. Ярианы хэлэнд ёс суртахуунгүй, муу үйлийг нүгэл, шударга, үнэнч, нигүүлсэхүй сэтгэл нь буян гэж ойлгох ч нүгэл, буян хэмээх ойлголтыг буддын шашны тайлбар толь, эх сурвалжуудад хэрхэн тодорхойлсныг дараах хүснэгтээс харж болно.

Хүснэгт 1. Буян, нүглийн тухай тодорхойлолт

Буян нь алив сайн жаргал, амгаланг үүсгэгч сэтгэл (Лувсанбалдан, 2009).	Буян хураах нь буддын шашны зан үйл. Бие, хэл, сэтгэлийг сайн үйлд зарахын нэр. Арван нүгэл тэргүүтэй муу үйлийг тэвчих гэсэн утга... (СУИС, 2016: 173).	Эх болсон зургаан зүйлийн амьтнаа бие, хэл, сэтгэлийн үүднээс тус болон гаслан зовлонгоос ангижруулах үйлийг буян хэмээн таалдаг (Чоймаа., Хүрэлбаатар ба бусад, 2000).
Нүгэл нь зовлон үүсгэгч муу сэтгэл (Лувсанбалдан, 2009).	Нүгэл нь буддын шашны зан үйл. Үүнийг арван хар нүгэл гэж хэлж заншсан бөгөөд хүн төрөлхтний өдөр тутмын амьдралд санаатайгаар үйлдэгддэг, үйлдэх магадлалтай муу үйлийг бие, хэл, сэтгэлээр үйлдэх гэж гурван бүлэгт хуваадаг... (СУИС, 2016: 173).	Гэм нь хилэнц тэргүүтэн зовлонгийн үрт үйл бөгөөд төрөлхийн ба төрөлхийн бус хоёр зүйл буй (Чоймаа., Хүрэлбаатар ба бусад, 2000).

Буддын ёс зүйн бодь сэтгэл нь үлэмж сэтгэлээс, үлэмж сэтгэл нигүүлсэхүйгээс, нигүүлсэхүй нь асрахуйгаас, асрахуй нь ач хариулахаас, ач хариулахуй нь ачийг дурдсанаас, ач дурдахуй нь “эх” хэмээн мэдсэнээс гэсэн **долоон** зүйлээс бүрдэж, үүнээс “**нигүүлсэхүй**” нь их хөлгөний мөрийн үндэс бөгөөд эхний гурван зүйл нь үр, сүүлчийн гурав нь шалтгаан гэсэн сэтгэл ба ухамсарлахуйн үйл. Харилцан уялдаатай эдгээр ойлголтыг ердийн ухамсрын түвшинд бараг ялгахгүй хэрэглэж хэвшсэн ч буддизмд ялгааг нь нарийвчлан тайлбарлажээ. Тухайлбал, хүсэл шуналаас салсан байдал нь **энэрэнгүй сэтгэл** юм (Ринбүүчий, 2008: 129). **Нигүүлсэхүй сэтгэл** нь уур хилэнгээс ангижрах явдал, гэгээрэхийн хэрээр нигүүлсэхүй чанартай болно. **Амарлингуй сэтгэл** нь өөрт чинь туслах хийгээд гомдоохын алинд ч тайван хүлээцтэй хандахыг хэлнэ. Эдгээр нь сэтгэл хэмээх субъектив дотоод ертөнцийн үзэгдлийн мэдрэмж, сэтгэл хөдлөл (зарим номд сэтгэлийн хөдөлгөөн гэжээ), хүсэл зэргийг илэрхийлж буй үгс болно. Эндээс буддын ёс зүйн ойлголтууд нь сэтгэлтэй салшгүй холбоотой нь харагдаж байна.

Нэр томъёоны орчуулга нь мета ёс зүйн судалгаанд маш чухал эх сурвалж болно. Буддын ёс зүйн сургаалыг анхны утгаас гажуудуулахгүйгээр орчуулж, тайлбарлах нь ёс зүйн мэдлэгийн системд болон практик ач холбогдолтой юм. Иймд “Нэрийтгэн найруулах 16 зарчим” баримжаанд “Гүн ухааны ба бусад аймагт үг олон утгаар илэрхийлэгдэх учир өөр өөрийн гол ёсонд ямар утгыг хадгалдаг бол тэр ёсоор үйлдэх. Үүний тулд аймаг тус бүрийн утгыг сайтар хөөн мэдэж орчуулах” (Дагвадорж, 1994: 33) хэмээснийг анхаарах нь зайлшгүй. Л.Хүрэлбаатар сургаалын орчуулгыг харьцуулсан хэсгээс “өглөг” хэмээхийг ухаарах олон хувилбарын утгыг мэдэж болно (1995: 140).

Хүснэгт 2. Цахар гэвч Лувсанчүлтэм, Лувсанринчин нарын орчуулга

Муу дордсыг асран өглөг өгч байвал Магад түүний нэр алдар салхин мэт дэлхий түгьюү <i>Цахар гэвч Лувсанчүлтэм. Сажса бандид Гунгаажалцан, 1958: 27.</i>	Өглөг дор насад туршигч түүний Үнэхээр алдар нэр хий мэт дэлгэрьюү <i>Лувсанринчиний орчуулга, Эрдэнийн сан нэрт сайн номлол оршвой. Буриад модон бар. х.6б.</i>
Үгээгүй ядууд өглөг өгөх нь баялгийн дээд <i>Цахар гэвч Лувсанчүлтэм. Сажса бандид Гунгаажалцан, 1958: 60.</i>	Аливаа эдийн дээд нь өглөг <i>Лувсанринчиний орчуулга, Эрдэнийн сан нэрт сайн номлол оршвой. Буриад модон бар. х.34б-35а.</i>

Манайд “буддист мета ёс зүй” гэдэг ойлголтыг төдий л хэрэглэдэггүй ч монгол мэргэд буддын тайлбар зохиолын баялаг уламжлалыг бүтээхдээ нэр томьёо, үг хэллэг, ёгт үгийн тайлбар, үндэслэгээг нотлох, няцаах аргаар ном хаялцаж буй мэт тайлбарласан нь өрнийн мета ёс зүйгээс онцлогтой юм. Эндээс үндэслэн бид буддист мета ёс зүйн хүрээнд нэр томьёог тогтоох, тодорхойлох, тайлбарлахдаа арга зүйн хувьд дараах хэдэн зүйлийг анхаарууштай. Үүнд:

- Буддизмын сэтгэлийн тухай сургаалыг буддын философийн өөрийнх нь арга зүйн зарчимд тулгуурлах.
- Буддын мэргэдийн зарлиг, ерөөл, айлдал зэрэг нь ёс суртахуунаас гадна соёлын агуулгатай (шашны зан үйл гэх мэт) байдаг тул энэ бүхнийг ёс зүйн түгээмэл онол мэт үзэх нь учир дутагдалтай. Жишээ нь, багшийг шүтэх ёсны сургаалыг XXI зууны багш мэргэжлийн ёс зүйн онолын үндэслэл мэтээр ярих нь утгагүй, харин дорнын ёс зүйн сэтгэлгээний нэг эх сурвалж гэж үзэн тайлбарлаж болно.
- Буддизмын эпистемологи, хэлний тухай олон эх сурвалжийг зэрэгцүүлэн авч үзэх, мөн хэвшсэн ойлголт, нэр томьёог уламжлалаас нь ангидуулахгүй, субъективизмд автахгүй байх.
- Ёс зүйн сэтгэлгээний нийтлэг ойлголтыг буддизмд хэрхэн тодорхойлж тайлбарладгийг харьцуулан үзээд зааг ялгамжтай оноох.
- “Мэргэд гарахын орны уг оршлын товч”-д “Бас үнэнээр бүтсэн хийгээд өөрийн бэлгэ чанараар бүтсэн хоёр хэтрүүлэгч төв үзэлтний ёсоор бөгөөс нэгэн утгатай тул нэгнийг ирэх газарт нөгөөгөөр орчуулж болохын учир буй боловч өөрийн үндэсний төв үзэлтний ёсоор бөгөөс тэр хоёр огт адил бусын тул нэгэн утгатай болгож үл болох мэт ч олны тул сайтар шинжилж өөр өөрийн ёсоор орчуулахыг мэдэх хэрэгтэй болой” (Ринчингаваа., Сэцэнцогт, 1992: 73) хэмээсэн ёсоор буддын философийн урсгал чиглэлүүдэд хэрхэн өгүүлснийг сайтар нягтлах зэрэг болно.

Нагаржунагийн хэлний талаарх үзлээр, уг юмс нь үнэхээр бүтээгүй учраас, бие даан эгнэгт байх юм гэж үгүй эгнэгт байх юм үгүй учраас энэ тэр гэж шууд тус тусад нь нэрлэн заасан тогтмол нэгэн утгатай байхын аргагүй, өөрийн чанараар үнэхээрийн байх аргагүй аж (Лувсанцэрэн, 2019: 236). Энэ нь XX зууны

ёс зүйд хувьсгал авчирсан хэмээн үнэлэгддэг Ж.Э.Мурын дэвшүүлсэн ёс зүйн ойлголтын мөн чанар, түүнийг үндэслэх боломжит тайлбаруудыг эргэцүүлэхийг чухалчилсантай адил үндэслэл гэж үзэхэд буруудахгүй. Учир нь Ж.Э.Мурын үзлээр “Сэтгэл ханамж бол сайн” гэж нотолж болох ч, энэ бодомжид тулгуурлаад “Сайн (бүхэн) сэтгэл ханамж өгдөг” гэвэл логик алдаанд хүрнэ. Харин сайн хэмээх категорийг бодит нэг зүйлтэй адилтгаж утгыг өргөтгөх нь **натуралист алдаа** [М.З уг чанарыг гажуудуулсан алдаа] болно. Иймд “сайн” хэмээх категори зарчмын хувьд тодорхойлогдошгүй” ажээ. Эндээс үүтгэн бодвол, буддизмын арга зүй нь Э.Мурын томъёолж буй натуралист алдаанаас ангид байх боломжийг бий болгосон гэж дүгнэж болохоор байна. Өөрөөр хэлбэл, буддын танин мэдэхүйд ойлголтын утгыг гажуудуулахгүй байх хэлний логикийн зарчим үйлчилдэг байна.

3.2. “Бодьсадвын явдалд орохуй шастрын дугуйт тайлбар” зохиолоос тодруулах нь

Буддист мета ёс зүйн шинжлэлийг тодруулах үүднээс зарим нэр томъёог эх сурвалж зохиол, түүний тайлбар зохиолтой нь харьцуулан дараах байдлаар жишээлэн авч үзлээ.

XVIII зууны “Мэргэд гарахын орон нэрт тогтоосон даяг”-ийн авидармын аймгаас (Ролбийдорж, 2021: 192) буян, буруу үзэл, найман гэм, хорин таван ахуй учир, нисваанист сэтгэл, сэтгэлээс болсон, арван нэгэн буян, жаран хоёр муу үзэл, Би-үгүй, буяны түүнчлэн чанар, шуналыг шүтсэн, сурахуун, бурууд орсон, сурахууны аймаг, үл сурахууны аймаг, эрдэм бүтээгч мөр зэрэг ойлголтыг ёс зүйд холбогдуулан нэрлэж болох юм. Эдгээрийн зарим нь өнөөгийн ёс зүй, сэтгэл зүйн аль алины нэр томъёоны бүлэгт хамаарах бөгөөд тухайн эх зохиол, түүний тайлбарыг нь харьцуулан хоорондын ялгаа заагийг нь тодруулж судлах хэрэгтэй.

Эртний Энэтхэгийн Наландрын Их сургуулийн бандида Шантидэва гэгээний айлдсан “Бодьсадвын явдалд орохуй” шастир нь гэгээрэх мөрийн увдисыг тайлсан тул газар газрын их мэргэд тайлбар бүтээл бичжээ. Монгол сэтгэгчдээс бичээч цорж Агваандорж, Бэйлийн ламтан Агваандамба, Оргиочийн лам Лувсанбалдан гавж, Хувилгааны аймгийн Чойнзон цорж нар тайлбар зохиож төвөд хэлээр бичсэн байна. Энд Оргиочийн лам Лувсанбалдан гавжийн “Дугуйт тайлбар” гэж алдаршсан зохиолыг гавж Т.Булганы орчуулснаар (Сонинбаяр, 2009: 2) хэрэглэгдэхүүн болгож байна. Учир нь логикийн ухаанд тайлбарын нөхцөл байдалд онолын өмнөх буюу онолоос гадуур орших асуудалт нөхцөл ч нөлөөлдөг. Иймээс танин мэдэхүйн эх утгын олон хэмжээст, олон давхаргат тайлбар бий болдог нь мета ёс зүйн арга зүйн зарчимтай нэлээд тохирч буйг харуулахын тулд тайлбар зохиолоос нь зарим ойлголтын талаар жишээлж үзэхийг оролдов. Тус зохиолд уламжлалын дагуу асуулт, хариулт, эсэргүүцэх нь, хариулт, өмөөрөгч нэгэн бээр, утгыг хураангуйлах гэсэн бүтэцтэй хэсгүүд байх бөгөөд буддын логикийн баталгаа, няцаалт, гаргалгааны аргуудыг хэрэглэжээ.

Дурдан буй зохиол нь бодь сэтгэлийн тус эрдэм, нүглээ наманчлахуй, бодь сэтгэлийг батад барихуй ба бусдыг гэх сэтгэлтэй байх, сэрэмжлэхүй, ухамсарлахуй, тэсэхүй, хичээхүй, бясалгахуй, билиг барамид, бодисадвын зориулга ерөөл гэсэн арван бүлэгтэй. Тус шастирт:

*өөртөө тусын сэтгэл үүсэхэд л бусдын амгаланд тус хүргэсэнтэй адил бөгөөд **бодь сэтгэл төрнө** гэдэг бол аз завшаан, хилэнц нүглээс зовлон төрөх тул хамаг амьтны тусыг бүтээхэд буяныг зориулах, буян үйлдэхүйг өөртөө дадуулахгүй аваас хуурмаг хийгээд мунхаг болно. Бодь сэтгэлээс илүү буян гэж үгүй, додомдсоны ачийг хариулах, тэсэхүйд хичээх, уураа хянаж мөхөөгөөд амгалан болох, зовлон ирэхэд сэтгэлээ тогтоон үл хямрах, дайсан ба нөхрийн зохисгүйг үйлдсэнийг амар ажрах, яруу бус үгийг үл өгүүлэх, олз хүндлэлгүйдээ үл гутрах, буяныг эрмэлзсэнээр хичээх, ухаантай бол уйтгар үл гарах, агиинд садан болчхоод эгиинд дайсан болохоос сэргийл, газар орноо миниймхийлэн барилгүй өөрийн эрхээр эдлэх, жуулчлах нисваанист зарим нэгэн холд хэрэн тэнэхийн зовлонтой байдаг (Лувсанбалдан, 2009: 129) хэмээн номложээ.*

“Бодьсадвын явдалд орохуй” зохиолын бодь сэтгэлийн тус эрдмийг номносон нэгдүгээр бүлгийн:

Асралт бодь сэтгэл төрсөн тэр агшнаа

Амаргүй сансрын гянданд хоригдож энэлэгсэд

Амгалан ажрагсдын хөвгүүн хэмээн өгүүлэгдээд

Аяа, ертөнцийн тэнгэр хүмүүний мөргөлийн орон болуу... (Лувсанбалдан, 2009: 460) хэмээх мөргийг Лувсанбалдан гавж “Бодьсадвын явдалд орохуй шастрын дугуйт тайлбар”-г:

“Алив бодгалийн үндэснээ ерөөхүй болон орохуй их эрдэнийн бодь сэтгэл төрөх тэр даруйдын агшнаа нэр өөрчлөгдөж, үйл нисваанисын эрхээр орчлонгийн гянданд хүлэгдэж ядарсан амьтан мөн боловч тэрчлэн залрагсдын хөвгүүн хэмээн өгүүлэгдэх ялгамжаат нэрийг олж түүгээр нэрлэгдэх буюу. Утга нь өөрчлөгдөх буюу нэрийн ялгамжааг утгаар, ертөнцийн тэнгэр хүмүүн сэлт бээр алгаа хавсрах ба тахиж магтах болон мөргөвөөс зохист орон болох болой” хэмээжээ (2009: 35). Энэ нь аливаа зүйлийн нэр өөрчлөгдөх, нэршил тогтох, нутагших зэрэг үйл явцыг илэрхийлсэн байна. Харин орчуулагчийн дагалдуулал үгийн тайлбарт **“Бодь сэтгэл:** Хамаг амьтны тусыг бүтээхийн тулд бурхны хутгийг олсугай хэмээн эгээрэх их төрөлхтөн хүний их сэтгэл. Өөрийнхөө тусад бус зөвхөн бусдад туслах, зөвхөн бусдын төлөө хэмээх цаглашгүй үйл хэргийг бүтээхээр их үүрэг, хариуцлагыг өөртөө хүлээж, тэр үүргээ биелүүлэхийн тулд оюун ухааны хөгжил боловсролын дээд хутаг болсон бурхны эрдэм ухааныг чухалчлан эгээрэх, их нигүүлсэл, энэрлийн үндэст “бодисадва нарыг мэндлүүлэгч эх, Их хөлгөнөө орох гагц үүд, Их хөлгөний хамаг мөрийн товчоон” болсон дээд бодь сэтгэл” (Лувсанбалдан, 2009: 604) хэмээн тодорхойлжээ. Бусдын тусаас доройтох гэм, ухамсаргүй байхын гэм гэдэг нь эх зохиол ба

тайлбар зохиолд хэрхэн илэрч буйг дараах хүснэгтээс харж болно. Тайлбар зохиолд ойлголт бүрийн философи утгыг нарийвчилж, илүү дэлгэрэнгүй авч үздэг нь мета түвшинд илэрхийлж буй хэрэг юм. Гэхдээ тайлбар зохиол нь хэн гэдэг, ямар зэргийн эрдэм мэдлэгтэй зохиогчийнх вэ гэдгээс ихээхэн хамаарна.

Хүснэгт 3. Эх зохиол ба тайлбар зохиолд ойлголтыг илэрхийлсэн байдал

Ойлголт	Эх зохиол	Тайлбар зохиол
Ухамсаргүй байхын гэм	Ухамсаргүй сэтгэлтэн Урьд сонсож санаж бясалгавч Угаас ёроол цоорхой бумбын ус адил Угтаа дурдан санахуй огтоос үл төрөхүй... зэргээр айлджээ.	“...Ухамсаргүй бол оюун ухаан төгс хотол чуулахгүй, ухамсаргүй сэтгэлтэй бодгальс хүнд сонсох, санах, бясалгах ухаан урьд өмнө байсан ч ухамсарлах нь доройтсон учраас хожим саналаа ч тэрхүү номоо тогтоолгүй умартдаг. Үлгэрлэвээс ёроол нь цоорхой буюу нүхтэй бумбад ус юүлэвч үл тогтож барагдахтай адил” (Лувсанбалдан, 2009:460)
Бусдын тусаас доройтох гэм	Тэр ямагт бодисадва нарт Түрүүгээ унахын дотроос хүнд нь бөгөөд Тэр мэт алдас гарваас л Тэгээд хамаг амьтны үйлс сүлбэрүй Агшин төдийд амьтан бусдын Ариун буян дор тогтор үйлдвээс л Амьтны тус сүлбэрэх учир Аюус муу заяа хязгааргүй ирэх Гагц амьтны амгалан жаргалыг Гацааж бусниулахад өөрөө сүлбэрэх тул Гэгээт хөх огторгуй сацуу Гэгэлзэх амьтны амгаланг бусниулахыг хэлэх юун хэмээжээ.	“Бодь сэтгэлээ орхиж, бусдыг мэхлэгч тэр нь бодисадва нарын өөрийгөө магтаж, өөрөөс бусдыг муулах зэрэг язгуурын уналуудын дотроос хамгийн хүнд нь буюу. Энэ мэтээр язгуурын уналд унаваас бусдын тусыг санах санаа доройтож, хамаг амьтны тусаас доройтох буюу явдал мөрийн шүтээн доройтох болой. Гэсэн ч ойр зуурын язгуурын унал гарахад гол болсон амьтны тус үйлдэхээс доройтдоггүй. Харин бодь сэтгэлээ алдчихвал л амьтны тусаас доройтох тул бусад ялагдлаас ч хүнд хэмээн “Тайлбар”-т номложээ (Лувсанбалдан, 2009:460).

Тус зохиолд “**Эрдэм сэтгэлд харгалзах зургаа**” гэдэгт өглөг буюу өгөх сэтгэл, шагшаабад буюу сахих сэтгэл, тэсэх буюу амарлиулах сэтгэл, хичээх буюу эрмэлзэх сэтгэл, бясалгах буюу үл алгасрах сэтгэл, билиг буюу хоосон чанарыг онохыг (Лувсанбалдан, 2009: 126) дурдсан байна. Үүнийг өнөө үед “өдөр тутамдаа мөрдөх өглөгч зан, сургаал зарлигийг мөрдөн сахих, тэвчээр хатуужил үзүүлэх, уйгагүй зүтгэх, бясалгал, гэгээрэл гэх **зургаан дадал**” (Ринбүүчий Зопа, 2008: 129) хэмээн томъёолжээ. Мөн сэтгэлийн эрдмийг дадуулж чадваас “өглөгч, ёс журмыг дагагч, тэсвэртэй, хичээнгүй, бясалган бодогч, билиг билгүүнтэй” гэсэн зургаан шинжийг олж авдгийг Бурхан багшийн сургаалд “зургаан барамид” хэмээн нэрлэдэг (Чоймаа., Янжинсүрэн, 2014: 64) байна. Мөн “Буяны зүгт хичээхүйг дадуулж эцэстээ хүрэх нь ч сэтгэлд л харгалзана. Анхдугаар самади бясалгалын орны тэгш агуулахуй зэргийг бясалгах цагт, эрмэлзэн хичээх сэтгэл хүчтэй, тунгалаг тодорхой байж, бие хэлтэй хамааралгүйгээр зөвхөн гагц тэгш агуулах бясалгалыг хийсний үрд Эсруа тэнгэр тэргүүтний оронд төрдөг...” (Лувсанбалдан, 2009: 129) гэж тайлбарласан байна. Эндээс үзэхэд, буддын нэр

томьёог утгачлан болон дүйлгэн орчуулж, үгийн утга, үүргийг дэлгэрэнгүй, хураангуй тайлбар хийх аргачлал чухалчлагдаж иржээ.

4. Судалгааны үр дүн, хэлэлцүүлэг

Буддын ёс зүйн сургаал нь хүн төрөлхтний ёс зүйн мэдлэгийн тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг. Иймд буддын ёс зүйн нэр томьёоны тогтсон тайлбар оноолтын уламжлалыг авч, пали, санскрит, төвөд, монгол оноолт, тайлбарын онтологи-эпистемологийн харьцуулсан судалгаагаар өргөжүүлэх чухал юм. Ёс зүйчид буддын зарим ойлголтыг өөрсдийн онолын үүднээс эсвэл өөрийнх нь онцлогийг алдагдуулахгүйгээр тайлбарлах явцад өрнийн ёс зүйн онол, арга зүйгээр хандан аналогичлох дүр зураг түгээмэл ажиглагдаж буй.

Хэл сэтгэхүйн харилцан хамаарлын асуудал нь логик- хэл шинжлэлийн судалгааны гол асуудал. Жишээлбэл, нүгэл, буян хэмээх ойлголтыг хүмүүс өөрийн шашин шүтлэгийн үүднээс ойлгодог. Өнөө цагт буддын ёс зүйн агуулгатай нэр томьёо, категорийг ёс зүй, сэтгэл зүйн онол, логик-хэл шинжлэлийн үүднээс тайлбарлах нь мета ёс зүйн судалгаа, нөгөө талаар буддын тайлбар зохиолууд нь чухамдаа мета түвшний илэрхийлэл юм.

Цаашид буддын ёс зүйн нэр томьёоны судалгаанд зөвхөн толь бичиг эсвэл сурах бичгийн дагалдуулал тайлбарыг үзэхээс гадна, буддын эх зохиол ба тайлбар зохиолыг харьцуулан шинжилбээс түүний ойлголт, нэр томьёоны утга тодорхой, бүтэц ба хэлбэрийн хувьд зөв байхаас гадна буддын шашны соёлыг илүү танин мэдэх боломж бүрдэхийг бид буддист мета ёс зүйн шинжилгээ гэж нэрлэж болно.

5. Дүгнэлт

Мета ёс зүйд ёс суртахууныг илэрхийлсэн ойлголт, категорийн тодорхойлолтоос гадна түүний тайлбарыг чухалчилдаг. Иймд буддын эх сурвалжийн тайлбар зохиолуудыг ёс зүйн үүднээс харьцуулан шинжилж, түүнд хэрэглэгддэг нэр томьёонуудыг оновчтой тодорхойлох боломжтой. Ялангуяа монгол буддист мэргэдийн тайлбар зохиолуудыг шинжилж, эх бичгийн харьцуулсан шинжилгээ хийх хэрэгцээ шаардлага буй.

Буддын тайлбар зохиолуудад “ёс зүйн тайлбарт шинжилгээ” хийхэд төвөд, санскрит хэлнээс нэр томьёог зөв оноон орчуулах, холбогдох нэмэлт тодруулгыг нарийвчлах шинжлэх нь зүйтэй юм. Жишээ нь, Шантидэва гэгээний айлдсан «Бодьсадвын явдалд орохуй» шастирын тайлбар зохиолоос гурван үүд гэдэг нь бие, хэл, сэтгэл; хутагтын долоон эрдэнэ нь сүсэг, шагшаабад, сонсохуй, өглөг, ичгүүрийг мэдэх, сонжуурт, билиг; хоёр тус нь өөрийн хийгээд бусдын тус болно зэргээр тайлбарласныг мэдэж болно. Буддын төв үзлийн үүднээс нөхцөл өөрчлөгдөхөд үгийн утга дагаж өөрчлөгддөг хэмээн үздэг нь хэлний мета түвшний илэрхийлэлд харгалзах боломжтой. Эндээс ёс зүйн нэр томьёоны тодорхойлолтуудыг бодит

(реалист) хийгээд харьцангуйгаар (релятивист) авч үзэх боломжтой нь харагдаж байна. Ёс зүйн ойлголтууд нь үнэлэмжийн утгатай ч тэдгээрийн тодорхойлолт нь нэр томъёо судлалын ерөнхий шаардлагад нийцэх учиртай.

Ном зүй

- Баясгалан, А.** (1995). *Төвд-Монгол хэлний толь бичиг*. Ред. Булган, Т. Улаанбаатар: Өнгөт хэвлэлийн үйлдвэр. [Bayasgalan, A. *Tövöd-Mongol khelnii toli bichig* [Tibetan - Mongolian Dictionary]. Ed. Bulgan T, Ulaanbaatar. 1995]
- Дагвадорж Д.** (1994). *Монголын гүн ухааны уламжлалт тогтсон таалал (Мэргэд гарахын орон дээж бичгийн сурвалжаар)*. Улаанбаатар. [Dagvadorj, D. *Mongolyn gүн ukhaany ulamjlalt togtson taalal* [Dagvadorj, D. Mongolian Philosophy] Ulaanbaatar. 1994]
- Дагвадорж, Д.** (2002). *Бурханы шашин, монгол уламжлал*. Улаанбаатар. [Dagvadorj, D. *Burkhany shashin, mongol ulamjlal* [The Buddhist religion and Mongolian tradition]. Ulaanbaatar. 2002]
- Лувсанбалдан.** (2009). *Бодьсадвын шастир*. Орч. Булган, Т. Улаанбаатар. [Luvsanbaldan. *Bodhisatvyn shastir* [Bodhisatva shastra]. Trans. Bulgan, T. Ulaanbaatar. 2009]
- Лувсанбалдан** (Оргиочийн лам). (2009). *Бодьсадвын явдалд орохуй шастрын дугуйт тайлбар*. Ред. Сонинбаяр, Ш., Орч. Булган, Т. Улаанбаатар: Нью Майнд. [Luvsanbaldan. *Bodhisatvyn yavdald orohui shastryн duguит tailbar* [Bodhisatva shastra commentary]. Ed. Soninbayar, Sh., Orchuulagch Bulgan, T. Ulaanbaatar: New Mind, 2009]
- Лувсанцэрэн Г.** (2019). *Нагаржунагийн философийн үзэл, төв үзлийн философийн онолын үндэс* Боть I. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК. [Luvsantseren, G. *Nagarjunagiin philosophiin үзэл, төв үзлийн philosophiin onolyn үндэс* [Nagarjuna's philosophy and basics of Madhyamaka theory]. Vol I. Ulaanbaatar: Soyombo printing, 2019]
- Лувсанцэрэн, Г., Ариунаа, Э.** (2007). *Буддын уламжлалт ухааны үндэс*. Улаанбаатар. [Luvsantseren, G., Ariunaa, E. *Buddyn ulamjlalt uhaany үндэс* [The Basic of Buddhist traditional knowledge]. Ulaanbaatar. 2007]
- Ринбүүчий Зоп.** (2008). *Сэтгэл амарлихуйн үүд*. Улаанбаатар. [Renbүүchii Zopa. *Setgel amarlikhuin үүд* [Renboche Zopa. The Joy of Compassion]. Ulaanbaatar: 2008]
- Ринчингаваа., Сэцэнцогт.** (1992). “Мэргэд гарахын орны уг оршлын товч”-оос. Монгол бичгээс хөрвүүлсэн Дашжамц Д., Шагдар А. *Бодрол, бясалгал*. №03, 73. [Rinchingavaa., Setsentsogt. “*Merged garahyn orny ug orshlyn товч*”-оос. *Bodrol Byasalgal* [Foreword Attaining of Wise people]. Ulaanbaatar: Soyombo printing. Trans. Dashjamts, D., Shagdar, A. 1992. *Bodrol Byasalgal*. №03, 73]

- Ролбийдорж.** (2021). *Мэргэд гарахын орон нэрт тогтоосон даяг*. Улаанбаатар: Бэмби сан. [Rolbiidorj. *Merged garahyn oron nert togtooson dayag* [Towards Attaining Wisdom] Ulaanbaatar: Bembi san. 2021]
- Сонинбаяр, Ш.** (2009). Редакторын үг, *Бодьсадвын явдалд орохуй шастрын дугуйт тайлбар*. Орч. Булган, Т. Ред. Сонинбаяр, Ш. Улаанбаатар: Нью Майнд. [Soninbayar, Sh. Redaktoryn üg. *Bodhisatviyn yavdald orohui shastriin duguit tailbar* []]. Trans. Bulgan, T. Ed. Soninbayar, Sh. Ulaanbaatar: New mind. 2009]
- СУИС.** (2016). *Шаашин соёл. Соёл урлагийн тайлбар толь*. Б. II. Улаанбаатар. [Soyol Urlagyn Ikh Sugruuli. *Shashin soyol. Soyol urlagiin tailbar toli* [The Religion and culture: Glossary of culture and arts]. Vol. II. Ulaanbaatar. 2016]
- Хүрэлбаатар, Л.** (1995). *Монгол орчуулгын товчоон*. Ред. Аким, Г. Улаанбаатар. [Khürelbaatar, L. *Mongol orchuulgyn товчоон* [The Story of Mongolian translation]. Ed. Akim, G. Ulaanbaatar: 1995]
- Чоймаа, Ш., Хүрэлбаатар, Л.** (2000). *Буддын шаашин соёлын тайлбар толь*. Боть. 1-2. Ред. Хүрэлбаатар, Л. Улаанбаатар. [Choimaa, Sh., Khürelbaatar, L. *Buddyn shashin soyolyn tailbar toli* [The Glossary of Buddhist religion and culture]. Vol. 1-2. Ed. Khürelbaatar, L. Ulaanbaatar: 2000]
- Чоймаа, Ш., Янжинсүрэн, С.** (2014). *Сэтгэлийг ариусгахуй*. Улаанбаатар: Тэгш түмэн зоос. [Choimaa, Sh., Yanjinsüren, S. *Setgeliig ariusgakhui* [Sanctification the mind]. Ulaanbaatar. 2014]
- Buddhist Ethics. (1995). Ed, K.R.John, *International Encyclopedia of Ethics*. London & Chicago: Salem press Inc.
- Cooper, D. E.** (2005). *Buddhism, Virtue and Environment*. Hants Burlington: Ashgate.
- Daniel, Cozort., James, Mark Shields.** (2018). *The Oxford Handbook of Buddhist Ethics*. OUP.
- Davis, G.** (2013). Moral Realism and Anti-Realism outside the West: A Meta-Ethical Turn in Buddhist Ethics. *Comparative Philosophy*, 4, 24-53.
- Edelglass, W.** (2014). Buddhist Ethics and Western Moral Philosophy. Emmanuel E.B, *A Companion to Buddhist Philosophy*. John Wiley&Sons, Inc. DOI: 10.1002/9781118324004. ch31
- Finnigan, B.** (2011). Buddhist metaethics. *Journal of the International Association of Buddhist Studies*, (Number 1-2, 2010), 267-297.
- Finnigan, B.** (2018). Madhyamaka Ethics. E. b. Shields, *The Oxford Handbook of Buddhist Ethics*. 162.
- Hare, R.M.** (1952). *Language of Morals*. Oxford, 202.
- Keown, D.** (2001). The Nature of Buddhist Ethics. Hampshire: Palgrave Macmillan.
- Keown, D.** (2001). *The Nature of Buddhist Ethics*. Hampshire: Palgrave Macmillan. Hampshire: Palgrave Macmillan.
- Railton, P.** (1998). Analytic ethics. In The Routledge Encyclopedia of Philosophy. Taylor and Francis. 24 Aug. 2023, Available at <https://www.rep.routledge.com/articles/thematic/analytic-ethics/v-1>. doi:10.4324/9780415249126-L003-1

- Velez de, C.A.** (2004). The Criteria of Goodness in the Pali Nikayas and the Nature of Buddhist Ethics. *Journal of Buddhist Ethics*, 123-142. <http://jbe.gold.ac.uk/>.
- Zolzaya, M.** (2019). Metaethics and Agvaandandar Ikharamba's teaching. *Шалгадаг ухааны судалгааны өгүүлэл [Shalgadag ukhaany sudalgaany ögüülel]*, 342-349.
- Бонгард-Леви, Г.** (1972). Буддологическое наследие Ф.И.Щербатского. *Индийская культура и буддизм*. Наука, 31 с.
- РАН.** (2001). Новая философская энциклопедия: в 4 т. / Нац. обществ.-науч. фонд; Предс. научно-ред. совета В.С. Степин.